



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 1102

Алтай хот

Тусгай зөвшөөрөлд нэмэлт оруулах  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Туркийн хамтын ажиллагааны "Тика" олон улсын байгууллагаас хэрэгжүүлсэн төслийн хүрээнд Есөнбулаг сумын 10 дугаар цэцэрлэгийн барилгыг өргөтгөж, шинээр 3 бүлэг ажиллуулах болсонтой холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны газрын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дүгнэлтийг үндэслэн тус цэцэрлэгийн 0003848 дугаартай сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлд нэмэлт оруулсугай.

2. Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлд нэмэлт оруулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Л.Отгончимэг)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Д.Алтанзагас)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР